

ЮАНЬ УЛСЫН ОРДНЫ ЁСЛОЛЫГ СУРВАЛЖИЙН БАРИМТААР
ТОДРУУЛАХ НЬ

Т.Отгонтуул
Д.Ундрах
Н.Золзаяа

Хураангуй: Энэхүү илтгэлд “Юань улсын судар”-ын “Хөгжмийн ойллого” бүлгийг шүүн үзэж нүүдэлчдийн байгуулсан төрт улсууд “Ёслол хөгжим” хэмээх ойлголтыг төрийн ёслолдоо хэрхэн авч хэрэглэсэн талаар сурвалжийн баримтад тулгуурлан тайлбарлахыг зорьсон болно. Чингэхдээ хятадын уламжлалт “Ёслол хөгжим” хэмээх ухагдахууны үүсэл хөгжил, ёслол журмын талаарх судлаачдын үзэл хийгээд хятад эх сурвалжуудын мэдээг шүүрдэн харьцуулан тайлбарлалаа.

Оршил

“Хөгжмийн ойллого” бүлэг нь хятадын 24 төрийн түүх хэмээх сурвалжуудад заавал багтдаг нэг бүлэг юм. Хятадын төрийн түүх Сыма Чянь-ийн бичсэн “Түүхийн тэмдэглэл”-ээс эхтэй хятадын төрт улсуудын албан ёсны төрийн түүхэнд багтах агаад дундад эртний үед хятадын газар нутагт нүүдэлчдийн байгуулсан төрийн түүхүүд болох “Ляо улсын судар”-ын 54 дүгээр бүлэг буюу 1 дэвтэр, “Алтан улсын судар”-т 39, 40 дүгээр бүлэг буюу 2 дэвтэр, “Юань улсын судар”-т 67-71 дүгээр бүлэг буюу 5 дэвтэрт тус тус багтсан байдаг. “Юань улсын судар” сурвалжийн бичгийн онцлог нь үгсийн шүдийг хурааж, тод, гаргацтай бийрээр татлан бичсэн байна. Сурвалжид буй хятад нэр, нэршлийг манж бичгээр дусал, бинт тавин ялган бичжээ. Бичээч бичсэн үгээ дараад, хажууд нь залруулан бичих, үгийг сольж бичсэн зүйлс цөөнгүй байна. Хуудас бүрт нь ямар нэгэн дэс дугаар, хүрээ байхгүй, бүлгийн эхэнд “Юань улсын судрын жаран долоодугаар дэвтэр”, “Ёслол хөгжмийн тэмдэглэл арван наймдугаар” хэмээх мөрүүдийг мөр тэтгэн бичсэн байна.

Ёслол хөгжим гэж юуг хэлэх вэ?

Хятадын уламжлалт ёсны нэг болох энэхүү ойлголтын талаар домогт өгүүлснээр, Жоу улс эртний тогтолцоо дээр тулгуурлан, Инь Шаны ёслолтой харьцуулан ёслолын хөгжмийг зохиосон гэдэг. Энэ тухай хятадын бүжгийн түүх судлаач нар: “Энэхүү маш чухал үйл явдлаар дамжуулан эртний овог аймгийн тахилгын хөгжимт бүжгүүдийг бүхлээр нь далайцтайгаар цэгцэлж, Жоу улсын сүр хүчийг бий болгосон төдийгүй өвөг дээдсээ хүндлэн бишрэх сэтгэлийг илэрхийлсэн юм. Жоу ван ёслол хөгжмийг зохиохыг чухалчлан улмаар үүнийгээ тэргүүн зэргийн чухал ажил болгон үйлджээ” (Ундрах, 2022: 47) хэмээн дүгнэжээ. Эндээс үзэхэд “Ёслол хөгжим” гэгч нь тахилга, тавиглах ёстой нягт холбоо бүхий найрал хөгжим, дуу бүжгийн цогц байсан ажээ. Эртний Жоу улсад энэхүү тахилгын үйлийн цогцыг нэгэн ойлголтод оруулж, төрт улсын эзэн хаадын заавал үйлдэх журам болгосныг хятадын түүхийн сурвалжуудаас үзэж болно.

“Ёслол үйлдэх” хэмээгддэг, олон төрлийн хууль дүрэм хэм хэмжээг тогтоож, сүнс сахиулсан, улс төр, аж ахуй, цэргийн үйл, хууль цааз хийгээд хүмүүсийн хэлцэж ярьж байдаг

цээр зэрэг нийгмийн амьдралын бүхий л талыг холбогдуулан хүндлэн тахиж, үйл журмаас өвөг дээдсийн тахилга хүртэл, хурим гашиудлаас өдөр тутмын хэрэглээний үг хүртэл бүгдийг “Ёс” хэмээн үзэж нэгэн төрлийн хаа ч байхгүй “ёс журам”-ыг бий болгожээ” (Ундрах, 2022: 47).

“Ёс” гэдэгт “Өлзийт ёс” буюу тахилга болон хөрш улсын чөтгөр сахиулсанг хүндлэх ёслол, “Муу ёс” буюу гашуудал, үхэл хагацал, оршуулгын ёслол, “Зочны ёс” буюу улсын холбоонд байх овог аймгуудын ёслол, “Цэргийн ёс” буюу цэргийг удирдаж ард олныг хөдөлгөх ёслол, “Хүндлэлт ёс” буюу хуримын дайллага ёслол багтдаг бөгөөд ёслол бүрд тоглож буй хөгжимтэй нь хамт “Хөгжим үйлдэх” гэж нэрлэдэг байжээ.

“Ляо улсын судар”-ын 54 дүгээр бүлэгт бүлэг буюу “Хөгжмийн ойллого” бүлэгт ёслол хөгжмийн талаар дурдалгүй Ляо улсын хөгжмийн бүлгийн талаар өгүүлж эхэлсэн байдаг. Харин энэ талаар “Алтан улсын судар”-ын: “Зуожуань судар”-т өгүүлснээр “Улсын ван их гавьяат үйлсийг дуусгаад хөгжмийг зохионо, төрийг тогтоогоод ёсыг үйлдэнэ” гэжээ. Зөвхөн эртний хоёр хаан, гурван хааны үед тэмдэглэгдэн үлдсэн төдийгүй тэнгэрийн доорхыг нэгтгэн захирагч нь хууль ёсыг нэгэн замд оруулж, ёс заншлыг засаж, хүмүүн бурханд нийцүүлэн, дээр дооргүй эв эетэй амьдрахдаа Ёслол хөгжмөөс өөр юунд түшиглэж байсан бол? Алтан улс эхэнд нь Сүн улсад чулуун хөгжим байсныг шууд зээлж авчээ”¹

“Юань улсын судар”-ын 67 дугаар бүлэгт “Ёслол хөгжим”-ийн тухай мөн л дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.² Үүнд: “Шастир”-т өгүүлсэн нь ёслол хэмээгч тэнгэр газрын дэс болой. Хөгжим хэмээгч тэнгэр газрын найрамдуу болой. Ёслолыг гүйцэтгэж биеэ засмуй. Гадаад байдал агишин зуур хэмээн төв үгүй, хичээнгүй үгүй болбоос усан хөнгөн сэтгэл орж ирмүй. Сэтгэлийг гүйцэтгэж сэтгэлийг засмуй. Сэтгэлийн дотор агишин зуур найрамдуу үгүй цэнгэл үгүй болбоос хөндий хуурмаг сэтгэл орж ирэх болой. Эртний ёслол хөгжмийн нэгэн дэвтэр эзэн болсон хүний бие сэтгэлд тиймийн тул, түүний хэрэглээ болсон нь бардаагаар хэлхээ үүрдийг байгуулан хэв хуулийг зузаатгамуй. Хойч үеийн ёслол хөгжим түүний уг үгүйн тулд гагцхүү хэрэг мэдэгчид харьяалагдаж, хэргийг дагамуй...” хэмээжээ. Үргэлжлүүлэн Юань улсын ордны “Ёслол”-ын тухай дэлгэрүүлэн авч үзье.

Ёслолыг хэдий үед тогтоосон бэ?

Шызү (世祖 Shizǔ) ³ Жыюань-ий (至元 Zhì yuán) наймдугаар оны (1271) намрын найман сарын шарагчин хонин өдөр анх “Бараалхах ёсон”-ыг үүсгэжээ. “Хөгжимгүй бол ёслол бүрдэхгүй” гэсэн зарлигаар “Сургах газар”-ын хөгжимч нарыг нэгжин сурвалжилж, хэнгэрэг дэлдэх, хөндлөн бишгүүр тоглох хөгжимч нарыг олж, тэдгээрийг сургаж, жигдрүүлэн “Бараалхах ёсон”-ыг үүсгэсэн байна. Ийнхүү “Бараалхах ёсон”-ыг хийхэд зориулан 200 гаруй хүнийг сургажээ. Найман сард “Хааны цолны өдөр” тохиожээ. Өөрөөр хэлбэл эзэн хааны эснэсэн өдөр (天寿圣节 tiān shòu shèng jié) юм. Үүнээс үүдэн “Бараалхах ёсон”-ыг хэрэглэжээ.

“Ёслол” нь хүний аливаа явдлын явбаас зохих зүйг дагуулан, хууль дүрэм тогтоож мөрдөж журамлахын хэмжээлэг болгосныг ёслол хэмээмүй. Бэр буулгах, охин өгөх ба баяр, тайлга тахилга, хурим хуй зэргийн их явдлаас эхлэн аль нэгэн үзэх, сонсох, хөдлөх, хэлэлцэхийн өчүүхэн бага газарт ёслолоос зөрж үл болох тул хүний биеэ засахын үндсэн хичээл ёслолоос чухал нь үгүй. Өршөөл, журам, ёслол, мэргэн, батыг таван ашид хэмээмүй.⁵ Юань улс хятадыг

¹ 《传》曰：“王者功成作乐，治定制礼。” 岂二帝三王之弥文哉！盖有天下者，将一轨度、正民俗、合人神、和上下，舍礼乐何以焉。金初得宋，始有金石之乐，然而未尽其美也。及乎大定、明昌之际，日修月葺，粲然大备。其隶太常者，即郊庙、祀享、大宴、大朝会宫县二舞是也。隶教坊者，则有铙歌鼓吹，天子行幸卤簿导引之乐也。有散乐。有渤海乐。有本国旧音，世宗尝写其意度为雅曲，史录其一，其僇者弗载云。

² Бид энэхүү өгүүлэлдээ “Юань улсын судар”-ын монгол орчуулгыг Дандаа чинсаны орчуулгаас эш татан авлаа. Доктор Т.Отгонтуул, магистрант Н.Золзаяа нар монгол бичгээрх эхийг кирилл бичигт хөрвүүлэн, доктор Д.Ундрах 1976 онд Жунхуа Шүжю хэвлэлийн газраас эрхлэн хэвлүүлсэн хятад эхтэй харгуулан тулгаж нягталсан болно.

³ Хубилай хаан.

⁴ Төр ёс, хууль ёс, дүрэм ёс тэргүүтэн аливаа дагаж явбаас зохих сайн мөр журмыг ёс хэмээмүй. (Хорин наймтын толь. 1998 х.)

⁵ Өдөр тутмын хэрэг явдалдаа сахиваас зохих зүйл нь дараах таван явдал гэж сургадаг. 1. Өршөөл (агуу тавиу, нэмүүн зөөлөн,

эзлэн сууж, “Бараалхах, хурах, хуримлах, тайх, тахих” зэрэг ёслолыг үйлддэг байжээ. “Эрхэм цол хүлээн авах”, “Их хатан эх (太皇太后 *Tài huáng tài hòu*), хатан эх навчит өргөмжлөл⁶ өргөх”, “Навчит өргөмжлөлөөр хатан, хунтайж өргөмжлөх” болон “Аливаа улсын гэрийн их хууль ёслол”-ыг цөм өвгөдийн сүмд хэлж тайна. Юань улсын ордонд “Цагаан сарын цагаалах өдөр бараалхах ёсон “Хаан сууринд суугаад бараалхахыг хүлээн авах ёсон”, “Олон түшмэд хаанд эрхэм цол өргөх ёсон”, “Хатанд навчит өргөмжлөл өгөх ёсон”, “Хунтайжид навчит өргөмжлөл өгөх ёсон”, “Их хатан эхэд эрхэм цол өгөх ёсон”, “Өвгөдийн сүмд хэлж тайхыг хамааран явах ёсон”, “Улсын судрын яамнаас урьд хааны магад хуулийг давшуулах ёсон” зэрэг ёслолуудыг үйлдэж байжээ. Эдгээр ёслолын ихэнх нь Тан улсын хууль ёсыг дагасан аж.

Ёслол үйлдэх сүм, хийд, орд харшийг тус тус нарийн зааж, аливаа “Ёслол”-ын үед хэн, хэзээ, ямар үйл хийхийг цагийн дарааллаар тодорхой өгүүлсэн байна. Аливаа үйл хэргийг удирдах хүний нэр, хэргэм зэргийг тусгайлан дуудаж, ёслолд оролцуулдаг аж. *Жишээлбэл: “Цагаан сарын цагаалах өдөр бараалхах ёсон” хэмээх бүлэгт: “Асран зогсох хэлтсийн⁷ түшмэл (侍义使 *Shì yì shǐ*) болон дагалцах түшмэл өөр өөрийн дээлээ өмсөж орно. Жаргах харишийн өмнө хүрч зааны соёон пайз⁸ (牙牌 *Yá pái*) өргөн сөгдөнө. Хаан хаалгаар гарч сүйхэнд суухад ташуур гурван удаа дуугарна. Асран зогсох хэлтсийн түшмэл (侍义使 *Shì yì shǐ*) мөргөнө. Удирдах түшмэлүүд тус тус зүүн баруун талыг хувааж удирдаж явна. Тэгш сүх барьсан хүн (劈正斧 *Pī zhèng fǔ*) дунд хавьцаа явна. Удирдаж Их гэгээн харишийн (大明殿 *Dà míng diàn*) гадна хүрмэгц тэгш сүх барьсан хүн (劈正斧 *Pī zhèng fǔ*) туслан, хойш харж зогсоно. Дэс дараалан савтай дэхүүрийн хажууд зогсоно” хэмээн өгүүлсэн байна. Үргэлжлүүлэн Юань улсын ордны ёслолуудыг нэг бүрчлэн дэлгэрүүлэн авч үзье.*

Ёслолын өмнөх бэлтгэлийн тухай

“Цагаалах сарын цагаалах өдөр бараалхах ёс”, “Хунтайжид навчит өргөмжлөл өгөх ёс” зэргийг үйлдэхдээ гурван өдрийн өмнөөс, “Хаан сууринд суугаад бараалхахыг хүлээн авах ёсон”, “Олон түшмэд хаанд эрхэм цол өргөх ёсон”, “Хатанд навчит өргөмжлөл өгөх ёсон”, “Их хатан эхэд эрхэм цол өгөх ёсон”, “Өвгөдийн сүмд хэлж тайхыг хамааран явах ёсон”, “Улсын судрын яамнаас урьд хааны магад хуулийг давшуулах ёсон” зэрэг ёслолын бэлтгэлийг хоёр өдрийн өмнөөс эхлэн базаадаг байна.

Юань улсын судрын 68 дугаар бүлэгт өгүүлснээр “Хунтайжид навчит өргөмжлөл өгөх ёсон”-ыг үйлдэхдээ “Гурван өдрийн өмнө баруун талын Чинсан зуун түшмэдийг авч алтан хасын хорооны навчит өргөмжлөл, эрдэнийн ширээний өмнө хүрч ёсолно. Ёслохдоо тушаалд байгаа бүх түшмэлд соёон пай гаргаж сөгдөөд, гурван удаа хүж барина. Хоёр өдрийн өмнө И Луань хэлтсээс (仪鸾司 *Yí luán sī*) навчит өргөмжлөл гаргах ширээг тавина. Зүүн талд эрдэнэ⁹ гаргах ширээг тавина. Эрдэнийг захирах түшмэл Хунтайжийн харишийн өмнө, яндрын дээр хүжсийн ширээ тавина. Баруун талд навчит өргөмжлөлийн ширээ тавина ...” хэмээсэн байдаг.

асрал сайн, энэрэн өршөөхүйг хэлнэ. Сэтгэлийн эрдэм болой. 2. *Журам* (бас чин гэдэг) (хүчирхэг идэрхэг, хатуу цул, шаламгай тасархай, хурц эрсийг хэлнэ. Зохицол, сэтгэлийн нийлэлцэхүй буюу.) / 3. *Ёслол* (ариун, дунд төв, хөнгөн эсгэй, найр тавиу, бишрэлтэйг хэлнэ. Дүрэм, сэтгэлийн зүй буюу) 4. *Мэргэн* (цэцэн гэгээн, ухаантай мэргэн, утга ёс нарийн хянамгайг хэлнэ. Ухал, сэтгэлийн гаргалга буюу.) 5. *Бат* (бас итгэмж гэдэг) (үнэн магад, төв чигч, шударга номхон, найртай төвшнийг хэлнэ. Зузаан, сэтгэлийн үндэс буюу)

⁶ Хааны зарлигаар аливаа аливаа ван хийгээд хатан нарыг өргөмжилсөн тамгат бичгийг навчит өргөмжлөл хэмээмүй. (Хорин наймтын толь. 470 х.)

⁷ Нэг төрлийн ёслолын алба.

⁸ Зааны ясан пайз нь албан тушаалтны нэр, албан тушаалыг сийлсэн зааны соёогоор хийгдсэн бөгөөд зөвхөн түүгээр ордон руу орж гарах боломжтой байжээ.

⁹ Манжийн хааны хас тамгыг бусад тамгаас ялган өргөж *бообай* буюу *эрдэнэ* гэнэ. Дайчин улсын бүгд хуулийн хоёрдугаар дэвтэр, Дотоод яамны зүйлд тэмдэглэснээр нийт хорин есөн *эрдэнэ (бообай)* тамга буй. (Баярсайхан, М, Отгонтуул, Т. (2017), “Дайчин гурний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс” 9 боть, (Дагалга боть.22 х). УБ., Хааны хас боо тамгыг эрдэнэ хэмээмүй. Зүйл бүрийн газарт хэрэглэх эрдэнэ буй. (Гучин зургаатын тайлбар толь. 124 х.)

**Олон түшмэд хаанд (皇帝 Huángdì) эрхэм цол өргөх ёслол дуусаад бараалхах
баяр хийх ёсыг хүлээн авах нь**

Ёслолд хаан, хааны ууган хөвгүүн (皇太子 Huáng tàizǐ), олон ван (王 Wáng), татвар хатан (后妃 Hòufēi), гүнж (公主 Gōngzhǔ) дэс дараагаар харшид орно. Ташуур гурван удаа дуугарна. Навчит өргөмжлөл, эрдэнийг угтаж тавихад зуун түшмэл оролцоно. Хөгжим хэдий үед дуугарч, хэдийд зогсохыг тодорхой өгүүлсэн байдаг. Архи барих ёслол нь цагаалах өдрийн ёслолтой адил аж. Урьдын адил “Урт наслаарай” хэмээгээд мөргөж бүжиглэнэ. Харшид цуглаад жагсах ба хамгаалах түшмэл Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shìShì yì shì), ёслолын түшмэл (礼仪使 Lǐyí shǐ) хааныг дагуулан удирдаж суурины ойр Их гэгээн харшид (大明殿 Dà míng diàn) орно. Навчит өргөмжлөл эрдэнийг удирдаж төв хаалгаар ороход хөгжим дуугарна. Навчит өргөмжлөл, эрдэнийн ширээг хүжсийн ширээний өмнө тавина. Хөгжим зогсоно. “Бичиг цэргийн зуун түшмэд бүрэн, тэр” хэмээн өгүүлэхэд доош нь сууж босоод бие бөхийгөөд ёсолно. Бүгдээрээ яндарт хүрч ёсолно. Бүгд “Урт наслаарай” (山呼 Shān hū) хэмээн өгүүлнэ. Тодорхой тооны түшмэлүүд эрдэнийг өргөх бөгөөд өргөх үед хөгжим дуугарна. Навчит өргөмжлөлтэй холбоотой үйл хэргийг баруун талд үйлдэнэ. Харин эрдэнэтэй холбоотой үйлийг зүүн талд үйлдэнэ. Жагсаалын тэргүүлэгч үгийг гүйцэтгэн навчит өргөмжлөл эрдэнийн ёслолыг дуусгаж залбирна. Зарлан тунхаглагч түшмэл (宣徽使 Xuān huī shǐ) “Залбирсан ёсоор болтугай” хэмээнэ.

Хатанд навчит өргөмжлөл өгөх ёсон¹⁰

Хаан, хатан, хааны багш, түшмэлүүд оролцоно. Навчит өргөмжлөлийг удирдах, өргөх, барих, унших, өргөн барих, удирдах түшмэл Юэхуамэнь (月华门 Yuè huá mén) хаалгаар орно. Асран зогсох хэлтсийн (侍义司 Shì yì sī) түшмэл удирдана. “Хааны багш (太尉 Tài wèi)-аас доош цөм сөгд” хэмээнэ. “Хааны багш (太尉 Tài wèi)-аас доош бүгд бос” хэмээнэ. Үет цомцог¹¹ барьж, хатанд навчит өргөмжлөл, эрдэнийг өгнө. Дөрвөлжин тэргээр өргөж явна. Хөгжим эгшиглүүлж, Асран зогсох хэлтсийн, Ёслох түшмэл хааны багш (太尉 Tài wèi) жич навчит өргөмжлөл, эрдэнийн түшмэлийг удирдаж дагалцан хатны ордон хүрээнд хүрч ширээ засна.

Дотоод бараач хатанд тусалж, гурван удаа хүж бариад ёсолно. Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shìShì yì sī) түшмэл Тоү Сүн болон хатныг удирдан Их гэгээн харш (大明殿 Dà míng diàn) -ийн өмнө хүрч хишигт мөргөнө. Аялгуу дуусахад баруун талын Чинсан залбирч магтаад нь навчит өргөмжлөл эрдэнийн ёслол дуусна. Түшмэлүүд “Тэсгэл¹² баясалчин хаан хатан хамт түг¹³ түмэн насны өлзий өргөмүй” хэмээсэнд Зарлан тунхаглагч түшмэл (宣徽使 Xuān huī shǐ) “Залбирсан ёсоор болог” хэмээнэ. Баруун талын Чинсан мэхийж босоод, эргэж архи барих суудалд хүрнэ. Архи барих, айлтгал бичгийн хуудас, ёслолын юм барих, магтах, ёслох хуушаан бомбо¹⁴ баярын ёс өргөх ба харшийн дээр ихэд хуримлах зэрэг нь цагаан сарын цагаалах өдрийн ёсон лугаа адил. Хурим дуусахад ташуур гурван удаа дуугаргана. Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shǐ) түшмэл хааныг, Угтан оруулагч түшмэл хатныг удирдан жаргах харшид эгэх нь ирсэн дүрэмтэйгээ адил. Хааны багш (太尉 Tài wèi)-аас доош урд харшид өөр өөрийн албан хувцсыг өмсөнө.

¹⁰ Хэргэм зэрэг дээшлүүлэх ёсон.

¹¹ Өргөмжлөлд, урдал барьж явах цацаг унжуулсныг үет цомцог хэмээмүй. (Гучин зургаатын тайлбар толь. 124 х.)

¹² Тэвчээртэй.

¹³ Наяд буюу түг түмэн.

¹⁴ Даосын шашин хийгээд уг шашны санваартан. Манай эриний эхэн үед Энэтхэг, Төвөдөд улмаар Хятад дэлгэрсэн шашны урсгал.

Хунтайжид навчит өргөмжлөл өгөх ёсон

Ёслолд хаан, хунтайж, хааны багш, түшмэлүүд оролцоно. Үйлчлэгч (舍人 Shě rén) түшмэл ёс хамгаалах, удирдах, дагалцах аялгуу хөгжмийг шүхэр¹⁵ дэхүүрээр¹⁶ удирдан харшийн өмнө хүрнэ. Шадар цэрэг дөрвөлжин сүйхэнд ширээ засаад өргөнө. Навчит өргөмжлөлийн түшмэлээс дооших түмэд дагалцан ил яндрын доор хүрнэ. Хуваагдаж эргээд хоёр саравчны доор зогсоно.

Зуун түшмэд мацалхийлэн¹⁷ эргэнэ. Навчит өргөмжлөлийг дөрвөлжин сүйхэнд өргөж явахад хөгжим үүсгэнэ. Хунтайжийн ордны хаалганд хүрнэ. Шадар цэрэг ширээ зассан зовхист тэргийг өргөж яваад орж, ил яндрын доор хүрнэ. Ширээ зассан дөрвөлжин сүйх эргэж, хөгжим зогсоход навчит өргөмжлөлийн түшмэлээс доош дэс дараалан зогсоно. Хааны багш (太尉 Tàì wèi) урагш болж, “Зарлигаар түшмэл нар илгээж хичээнгүйл”, “Навчит өргөмжлөлийг өг” хэмээгээд байрандаа эргэнэ. Түшмэлүүд хунтайжид ёсолно. Хунтайж дэвсгэрт суудалд хүрч, урагш харж зогсоод сөгдөнө. “Эрдэнэ барих түшмэл босож ширээний өмнө хүрээд сөгдөж, эрдэнэ уншина. Уншиж дуусгаад савд хийнэ. Соёон пайз (牙牌 Yá pái) хавчуулан навчит өргөмжлөл, эрдэнийг авч сөгдөнө. Навчит өргөмжлөл, эрдэнийг хунтайж руу урагшлуулахад хичээнгүйлэн хүлээн авна. Хөвгүүн аваад зүүн баруун талын Сү Шы түшмэлд өгнө. Энэ үед хөгжим эгшиглэнэ. Хааны багш (太尉 Tàì wèi) архи барина. Бууж орондоо эргэмэгц хөгжим зогсоно. Аялгуу дуусмагц баруун этгээдийн Чинсан залбирч магтаал өгүүлнэ. Навчит өргөмжлөл, эрдэнийн ёслол дууссанд түшмэлүүд тэсгэлгүй баярлана. “Хүслээр хаан хатанд хамт түг түмэн насны өлзий өргөө” хэмээсэнд Зарлан тунхаглагч түшмэл (宣徽使 Xuān huī shǐ) түшмэл “Залбирсан ёсоор болтугай” хэмээнэ. Баруун этгээдийн Шү Зи түшмэл Хунтайжийг удирдаж ордонд эргэнэ. Бүгд албан хувцас өмсөн дэс дараалан сууцгаана. Баруун талын Чинсан төрийн хувцас өмсөнө.

Их хатан эхэд (太皇太后 Tàì huáng tài hòu) эрхэм цол өргөх ба навчит өргөмжлөл, эрдэнэ өгөх ёсон

Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shǐ) түшмэл соёон пайзыг өргөн барьж орно. Хаан хаалгаар сүйхэнд орж, ташуур гурван удаа дуугаргана. Хаан босож, навчит өргөмжлөлийг навчит өргөмжлөлийн түшмэлд өгнө. Навчит өргөмжлөлийн түшмэл сөгдөж, хүлээн аваад босоод өргөн барих түшмэлд өгнө. Соёон пайз (牙牌 Yá pái) гаргаж, эрдэнийг навчит өргөмжлөлийн дэслэгчид өгнө. Навчит өргөмжлөлийн дэслэгч сөгдөж, хүлээн аваад босож, эрдэнэ өргөн барих түшмэлд өгнө. Соёон пайз (牙牌 Yá pái) гаргана. Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shǐ) түшмэл удирдаж, дагалцах түшмэлтэй хамт их хатан эхийн (太皇太后 Tàì huáng tài hòu) жаргах харшийн өмнө хүрч сөгдөнө. Босох, суух, ёслох, бүжиглэх нь цагаан сарын цагаалах өдрийн ёслолтой адил. Магтаал удирдах түшмэл, навчит өргөмжлөлийн түшмэлээс доош нь эргэж, босох суух сууринд хүрнэ.

Хаан босож архи барина. Их хатан эхэд хундага өргөж, зүүн эргэнэ. Ууж дуусахад нь хаан суудалдаа сууна. Хаан хатан болон жич татвар хатан, гүнжийг авч яндраар бууна. Буугаад хойш харж ёслоод, баярын ёс хийж харш руу урагшилна. Аялгуу төгсөхөд жагсаалын тэргүүлэгч залбирч магтаал өгүүлэх нь “Навчит өргөмжлөл эрдэнийн ёслол дууссанд түшмэл бид тэсэлгүй баярлан хүсэх нь: “Их хатан эх (太皇太后 Tàì huáng tài hòu), хаанд түг түмэн насны өлзийг өргөө” хэмээнэ. Зарлан тунхаглагч түшмэл (宣徽使 Xuān huī shǐ) түшмэл “Нийлүүлэн залбирсан ёсоор болтугай” хэмээсэнд жагсаалын тэргүүлэгч мэхийж босоод ухарч, архи барих сууринд хүрнэ. Бүгдээрээ цагаан сарын цагаалах өдрийн ёстой адил. Их хатан эхэд (太皇太后 Tàì huáng tài hòu) эрхэм цол өргөх ба навчит өргөмжлөл, эрдэнэ барих ёс урьд ёстойгоо адил. Их хатан эхэд (太皇太后 Tàì huáng tài hòu) эрхэм цол нэмж өргөх ба навчит өргөмжлөл эрдэнэ барих ёс урьд өмнөх

¹⁵ Ямбатан хүмүүсийн толгой дээр нь барьж явдаг хоёр гурван дарвалгаа унжуулан, дугариг сүүдрэвч.

¹⁶ Шувууны өдөөр хийсэн шороо тоос гүвэх дэвүүрийн зүйл.

¹⁷ Их алхмаар түргэлэн явахуйг **Мацалхийлмуй** хэмээмүй (Гучин зургаатын тайлбар толь. 409 х.).

ёстой адил. Навчит өргөмжлөл, эрдэнэ гаргахад удирдах ба дагалцах нь зам ариутгах түшмэл, Жин Бай хоёр зүүн баруун талаар хувааж бүгдийг хамааруулж оролцоно. Олон түшмэд бүгд албан хувцас өмсөж, бараалын өмнө дэс дараалан зогсоно. Түшмэлийн хувцас бол нэгдүгээр зэргийн бараалхах хувцас байна.

Өвгөдийн сүмд хэлж тайхыг хамааран явах ёсон

Залбирах хавтгай модыг өргөж ороод хааныг оролцуулахыг гуйна. Улаан алтан гурамсан сиймхийгээр ширээг бүрж, шар сиймхий алчуураар хучна. Хааны хүж, хааны архийг өргөж энгийн ёс шиг залбирах газрыг ариутгаж хононо.

Хэлж тайх өдрөөс гурван мөчийн өмнө ёслолыг эрхэлсэн түшмэл лавлаж тодорхойлно. Өвгөдийн сүмийг эрхэлсэн түшмэлийн харьяатыг авч, сүм харшид ороод дүрэм ёсоор жагсаана. Ёслолыг эрхэлсэн түшмэл нэлээн урагш болж, ёсолно. Түшмэлүүд бүгд ёсолно.

Дараа нь хэлж тайх түшмэлийг удирдаж, угаалын савны дэргэд хүрнэ. Хундагыг угаагаад, сууринг угааж, хойш харж зогсоод соён пайзыг хавчуулна. Алчуур угааж, хундагыг зайлаад хундагыг арчиж, соён пайзыг барин гуйна. Соён пайзыг архины хундаганы газарт хүргээд, хавчуулын хундагыг барина. Хундагыг эрхэлсэн түшмэл бүрхүүлийг нээж авахад архи эрхэлсэн түшмэл архи уулгаад хундагыг хундага өргөн барих түшмэл өгнө. Соён пайз (牙牌 Yá pái) барьж Хунтайжийн гэрт хүрч дахиж ёсолно.

Хэрэг мэдэгч түшмэд хүж өргөнө. Хэлж тайх түшмэл соён пайз (牙牌 Yá pái) хавчуулан сөгдөөд гурван удаа хүж өргөн хундага барьж, гурван удаа архи барьж, дахиад хоосон хундагыг хундага өргөх түшмэлд өгөөд соён пайз (牙牌 Yá pái) барьж мэхийж босно. Залбирахыг өргөх түшмэл соён пайзыг хавчуулан сөгдөөд залбирах хавтгай модыг хослон өргөхөд залбирахыг унших түшмэл сөгдөж, залбирах бичгийг уншин дуусна. Залбирах бичгийг ширээнд тавьж, соён пайзыг барин мэхийж босно. Гэр бүр бүгд дээрх ёсны адил. Хунтайж дуусаад хэлж тайх түшмэлийг удирдаж, доош буугаад байрандаа эргэнэ. Дахиж ёслон дуусаад тайлган мах шатаах газарт хүрч залбиран тахиж, ёслон тал нь шатахад хэлж тайх түшмэлээс доош цөм эргэнэ. Тэр өдөр хэлж тайх түшмэл тус тус хүрэн хувцас өмсөнө. Ёслолыг эрхэлсэн түшмэл, хэлж тайх түшмэл нар тус тус хүрэн хувцас өмсөнө.

Улсын судрын яамнаас урьд хааны магад хуулийг давшуулах ёсон

Асран зогсох хэлтсийн (侍义使 Shì yì shǐ) түшмэл магад хуулийн ширээг удирдаж орно. Зарлигийг хүлээсэн дөрвөн хүн “Магад хуулийг” (实录 Shílù) өргөж төв яндраар дэвшинэ. Улсын судрыг харилцан зохиогч хааны хүжсийн ширээний өмнө хүрч зогсоно. Олон түшмэд бууж байрандаа эргэхэд зохих бичгийн утгач Вэй Зи түшмэл сууж, магад хуулийн өмнө хүрч сөгдөөд айлтгал бичиг уншина. Уншиж дуусмагц мэхийж босоод байрандаа эргэнэ. Хааны үзэж дуусахыг хүлээж байрандаа эргэнэ. Энэ үед улсын судрыг харилцан зохиогчоос доош цөм ёсолно.

Зарлигийг хүлээсэн түшмэл дэвшиж, магад хуулийг авч төв яндраар бууж ширээнд тавиад хаалгаар гарна. Аялгуу хөгжим ёслон дагалцана. Улсын судрын яаманд эргэж, танхимын дээр тавимагц бүгд ёслон, зуун түшмэд мацалхийлэн эргэнэ. Тэр өдөр олон яамны түшмэл бүгд албан хувцас өмсөнө.

Ёслолд хамаарах хөгжмийн аймаг

Дээрх ёслолуудтай салшгүй холбоотой нэгэн зүйл бол хөгжим юм. Юань улсын сударт өгүүлснээр Юань улсын ордонд “Өлзийт одон анги”, “Хөгжим аялгууны вангийн анги”, “Ёслол хөгжмийн анги”, “Ном номлох анги” хэмээх хөгжмийн дөрвөн анги, “Үүл найрамдах”, “Амар найрамдуу” зэрэг хөгжмийн аймаг хоёр байжээ. Уг хоёр хөгжмийн аймгаас гадна өөр

хөгжмийн аймаг байсан байх магадлалтай юм. Юань улсын сударт дээрх зөвхөн хоёр аймгийн тухай өгүүлсэн байна. Энэхүү хөгжмийн аймаг нь ёслолын үед хөгжим эгшиглүүлэхээс гадна түшмэдийн хянаж, ёсон алдахыг үзэж, торгууль торгодог байна.

Ёслолыг гүйцэтгэхэд “Үүл найрамдах” хэмээх хөгжмийн аймаг оролцдог байна. Хөгжимч нарын хувцас их жагсаалын хуулийн хувцастай адил. Сударт хөгжмийн аймагт хамаарах хүмүүсийн хувцсыг нэг бүрчлэн нэрлэсэн байна. Жишээлбэл: “Дөрвөлжин сүйхний ширээг өргөх түшмэл Тан Жинь¹⁸ малгай, хүрэн сиймхий, чухал ханиуит цамц, алт түрхсэн гуулин бүс, хар гутал өмсөнө. Хүжсийн ширээ дунд замын түшмэл, сүйхч найман хүний хувцас нь эрдэнийн ширээний сүйхчтэй адил. Хүжис баригч хоёр хүн зүүн баруун талаар хуваагдана. Хувцас нь дөрөвдүгээр зэргийн хувцас өмсөнө.” хэмээн өгүүлжээ.

“Үүл найрамдах” хэмээх хөгжмийн аймаг дараах хөгжмүүдийг ёслолд үед хэрэглэж байжээ. Ши зү, фэй шяо¹⁹, шяо гуань, пипа²⁰, шан, кунхөү²¹, ятга²², ван шянь, тэргүүн гуурсан бишгүүр²³, луут хөндлөн бишгүүр²⁴, найралт хэнгэрэг, луут бишгүүр, жинь гуань бишгүүр, шан, юун оу²⁵, хонх²⁶, цүн²⁷, их хэнгэрэг²⁸ зэрэг хөгжмийг хэрэглэнэ.

Улаан дүгрэг дэвүүр²⁹, бага дэвүүр, дунд гургуулын³⁰ дэхүүр, их гургуулын дэвүүр, их шүхэр, гэрэлт шүхэр, хүрэн дөрвөлжин шүхэр, улаан шүхэр, муруй шүхэр бан жянь, ү жин шидэм, сүх, дөрөөт шидэм, лией сэ болон мөн усны малуу³¹, алтны фөнше, босоо хэмх, алтан сандал³², ташуурын сав, бүрхүүлт эмээл, сул гар, хэвтээ хэмх зэргийг ёслол хөгжмийн үед хэрэглэнэ.

Хонх, шидэм, үүдний хиур³³, “чы чяо” хэмээх улаан хүрэн хуйт илд, “хуан чяо” хэмээх жад, “Ба чяо”³⁴ хэмээх шар хуйт илд, цагаан хуйт илд, хүрэн хуйт илд, хормогч хясуур, хуяг гутал зэргийг хэрэглэдэг ажээ.

Дээрх ёслолуудын бүрэлдэхүүний тухай

Эрхэм цол өргөх, навчит өргөмжлөл эрдэнэ өргөхөд нийт 216 хүн байна. Навчит өргөмжлөл өргөх түшмэл 4, эрдэнэ өргөх түшмэл 4, навчит өргөмжлөл өргөн барих түшмэл 2,

¹⁸ Тан (唐), Жинь (晋) улсын үед өмсдөг байсан хар өнгөт маажиндсан хар малгай. Ихэнхдээ түшмэд өмсдөг. Хожим Мин улсын үед сэргээж өмссөн байдаг.

¹⁹ Жигдэлсэн бишгүүр. “Ихэр арван зургаан бишгүүрийг зэрэглэж, нэг болгон үйлдсэнийг жигдэлсэн бишгүүр хэмээмүй. Бас хөгжмийн найман аялгуунд хэрэглэмүй.” (Хорин наймтын толь. 1915 х.)

²⁰ Модоор хийдэг, гуаны хэлбэртэй дээд хэсэг нь тахирдуу дөрвөн буюу зургаан чавхдаст хөгжмийн зэмсэг.

²¹ Кунхөү (箏篋). Таван хэлний зүйл хуваасан тольд “Ятгалаг” хэмээн орчуулжээ. Харин Хорин наймтын тольд “Дүрэм нь агуй их ятгатай адилхан. Урт нь хоёр тохой илүү, арван чавхдастай бөгөөд модны ишээр дарж хавиран дуугарахыг ятгалаг хэмээмүй” гэж тайлбарлажээ.

²² Юань улсын судрын 71 дүгээр бүлэгт “Агуу их ятганы мэт хоёр үзүүр нь өчүүхэн унжжээ. Тулгар буй. Арван гурван чавхдаст” хэмээн тайлбарлажээ.

²³ Юань улсын судрын 71 дүгээр бүлэгт “Тэргүүн бишгүүрийн (头管) хийх арга нь хулсаар гуурс болгожээ. Хулс өвсний навчийг нугалж тэргүүн болгожээ.” хэмээн тайлбарласан байна.

²⁴ Юань улсын судрын 71 дүгээр бүлэгт “Лууны хөндлөн бишгүүр (龙笛) хийх арга нь хөндлөн бишгүүрийнхэй адил. Долоон нүхтэй хөндлөнгөөр үлэнэ. Гуурсны үзүүрт лууны тэргүүн хийж, дотор нь бөсөөр зангиджээ.” хэмээн тайлбарласан байна.

²⁵ Yun б. Таван хэлний тольд “Дуу дарам” гэж орчуулжээ. Юань улсын судрын 71 дүгээр бүлэгт “Юун Оу (云璫) гуулиар хийжээ. Өчүүхэн харанга, арван гурав бүрнээ нэгэн модон тавиур доор урт иш буй. Зүүн гараар бариад баруун гарт өчүүхэн манцуурга барьж цохимуй. Бишгүүр хийсэн нь хөндлөн бишгүүрийн мэт таван нүхтэй.” хэмээн тайлбарласан байна.

²⁶ Алт, мөнгө, гууль, төмрөөр их багын хэмжээ адилгүйгээр олонхийг нь цутгаж үйлдмүй. Бас давтаж үйлдэх нь ч буй. Аль нь ч боловч хөндлөн бөгөөд дотор нь хэл хийж цохиж хөдөлгөөвөөс дуугарахыг хонх хэмээмүй. (Хорин наймтын толь. 939 х.)

²⁷ Эрт цагт архи хийж байсан мод, арьс, шаазан зэргээр хийсэн том сав.

²⁸ Дундаа хөндий, өргөн дүгрэг цагаригийн хоёр талыг арьсаар бүрж хийсэн, цохих, дэлдэх дохио өгөх хөгжмийн зэмсэг. (ц.т)

²⁹ Дэвэлхийлэн сэрүүцүүлэх хэрэгсэл, модон хавьсанд цаас бөс торгомсог нааж нугалбарлан хийнэ. (ц.т)

³⁰ Газар ухаж үүрээ барьдаг, бяцхан хошуутай хурц өнгөтэй, урт сүүлтэй, тахиатай төстэй, бие охор, жимс ургамлаар хооллодог шувуу.

³¹ Архины жижгэвтэр сав.

³² Сандлыг алтаар ширдэж алтан луу зурж жагсахуйг Алтан сандал хэмээмүй. (Гучин зургаатын тайлбар толь. 183 х.)

³³ Гурвалжин буюу дөрвөлжин хэлбэртэй бага туг далбаа. (Монгол хэлний толь. Норжин, Ц. 1345 х.)

³⁴ 1976 онд Жунхуа Шүжю хэвлэлийн газраас эрхлэн хэвлүүлсэн хятад эхтэй харгуулан тулгахад энэхүү хэсэг нь хятад эхэд алга байна.

эрдэнэ өргөн барих түшмэл 2, навчит өргөмжлөл удирдах түшмэл 5, эрдэнэ удирдах түшмэл 5, харшийн хянагч түшмэл 3, ёсныг хянах түшмэл 4, харшийн дотор харуул түшмэл 2, байцаан үзэгч түшмэл 4, хаалгач түшмэл³⁵ 3, зам ариутгах түшмэл 4, ёсыг хамгаалахыг тоолж үзэх түшмэл 5, хүжсийн түшмэл 4, зөвлөн асуухад бэлтгэх түшмэл 7, төлөө ёслох түшмэл 30, хумьж хамгаалах түшмэл 2, шидмийг удирдах түшмэл 2, дөрвөлжин сүйхний 160 хүн байна.

Ёслолын идээ ундаа

Аливаа их хуримд морь нэгээс хэтрэхгүй. Хонь хэдий олон ч гөрөөчин нарын барьсан шинэ нь гөрөөсний мах, загас, түүний нугалмай зэргийг хэрэглэнэ. Ёслолын үед архийг заавал хэрэглэнэ. Архийг баруун талын Чинсан барина. Архи барьсан Чинсан мэхийг босоод архи барих сууринд хүрнэ. Хүндэтгэн хундагалагч албат (尚醞官) түшмэл Чинсанд хундага өгнө. Чинсан зааны соёог хавчуулж, хундага өргөн хойш харан зогсоно. Хөгжимч нар хөгжим тоглож, дөрвөн удаа тоглогдоход Чинсан архи барина. Хаан хундага өргөхөд харшийн дээр, доор жигүүрлэн зогссон сайд түшмэл бүгд дахин ёсолно. Дөрөвдүгээр зэргээс дээших түшмэдэд харшийн дээр архи өгнө. Хууль татах түшмэл (典引) тавдугаар зэргээс дооших түшмэлүүдэд хоёр хаалганы доор архи өгнө. Асран зогсох хэлтсийн (侍义使) түшмэл хослон удирдаж, өмнө зүүн хаалгаар гарч сууринд ухрахад хөгжим зогсоно. Хүндэтгэн хундагалагч албат (尚醞官) түшмэл архи барихад харшийн дээр доор жигүүрлэн зогссон сайд түшмэл гурван удаа архи барьж дуусгана гэх зэргээр нарийн тогтсон журмыг заажээ.

Дүгнэлт

Монголчууд эртнээс ёслолыг үйлдэхийн тулд хөгжмийн зэмсэг, бүжгийн үйлийг орхилгүйгээр хамт хэрэглэдэг байсан нь “Ёслол” хийгээд “Хөгжим”-ийн чухал салшгүй холбоог харуулж байна. Үүнээс дүгнэхэд “Ёслол” үгүй бол “Хөгжим” үгүй. “Хөгжим” үгүй бол “Ёслол” үгүй гэж дүгнэж болохоор байна.

Сурвалжийн баримтаас харахад Монголын их Юань улсын үед ёслолын хэд хэдэн төрөл, хөгжмийн хэд хэдэн аймаг, анги, ай байжээ. Юань улсын сударт “Бараалхах ёсон”-ыг хийхэд зориулан 200 гаруй хүнийг сургаж, наймдугаар оны хаврын хоёр сард “Бараалхах ёсон”-ыг хариуцан захирах “Асран зогсох хэлтсийн (侍义司) яам”-ыг байгуулсан байна.” хэмээн тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд “Ёслол хөгжим” хэмээх нь хэдийнээ өөрийн гэсэн хэв маягаар баяжин олон төрөл хэлбэртэй болж, ид цэцэглэн хөгжиж байсныг харуулж байна. Ийнхүү “Ёслол хөгжим” нь төрөл зүйл болон өөрийн хэв маяг, дүрэм журмыг цогцлоон хөгжихөд ёслолын яам ихээхэн нөлөө үзүүлсэн бололтой. Ёслол хөгжмийн тухай зүйлийг Юань улсын сударт буй байдлаар нь сурвалжид тулгуурлан судалсан тул тухайн үеийн ёслол хөгжмийн зүйлийг илүү тодорхой, дэлгэрэнгүй байдлаар харах боломжтой юм.

Монголчууд аливаа ёслолыг үйлдэхдээ хэдэн өдрийн өмнөөс бэлтгэж, “Залбирах үг”-ийг хэд хэдэн удаа хянаж, засан сайжруулж байжээ. Энэ нь эрт үеэсээ “Ёслол” үйлдэхдээ журмыг чанд мөрдөж, ёс дүрмийн дагуу нарийн зохион байгуулалттай, хүндэтгэлтэй хийдэг байсан нь харагдаж байна.


Монгол төрийн ёслолын бүрэлдэхүүн нь маш олон, хэрэглэх хөгжмийн зэмсэг нь тоогоор арвин байсныг дурдах хэрэгтэй. “Ёслолд нийт 216 хүн оролцоно” хэмээн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Ёслолд хаад, хатад, хунтайж, ван тавнангууд, хувраг, гадаадын иргэдээс гадна энгийн ард, охид хөвгүүд бүгд оролцож байсан нь ёслолын сүр хүч, хэр хэмжээ, далайцыг харуулж байна.

Юань улсын судрын ёслолын бүлгүүдэд ёслол үйлдэх сүм, хийд, орд харшийг тус тус нарийн зааж, аливаа “Ёслол”-ын үед хэн, хэзээ, хаана байрлаж, ямар үйл хийхийг цагийн дарааллаар тодорхой өгүүлжээ. Аливаа үйл хэргийг удирдах хүний нэр, хэргэм зэргийг тусгайлан дуудаж,

³⁵ Хутагтын гэр хашааны үүдийг сахих ба гадагш зарлаганд явах ба зам удирдаж явах үүрэгтэй болно.

ёслолд оролцуулдаг байсан бөгөөд тэдгээрийн хувцас, ёслолын эд хэрэгслийг тодруулан дурдсан байдаг. Үүнээс үзэхэд цаг цагийн урсгалаар ёслол улам төгөлдөржиж, хөгжмийн зэмсгүүд хөгжсөөр байсан нь дамжиггүй.

Юань улсын хааны ордон Дайду хотноо шилжсэнтэй холбогдон монголын ёслол хөгжмийг олон үндэсний соёлоор баяжуулсны дотор хятад үндэстний хөгжим зэмсэг, ёслолын үг хэллэг, ёслох үйлийн нөлөө байсан бололтой.



Юань улсын судар (Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулга)

Ном зүй

- Аким Г., Баярсайхан М. (2015), *Юань улсын судар (Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулга) LX-LXIX дэвтэр*. Улаанбаатар.
- Аким Г., Баярсайхан М. 2015. *Юань улсын судар (Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулга) LXX-LXXIX дэвтэр*. Улаанбаатар.
- Бадраа Ж. 1998. *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар.
- Баярсайхан М., Отгонтуул Т. 2017. *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс, 9 боть, (Дагалга боть)*. Улаанбаатар.
- Дулам С. 1999. *Монгол бэлгэдэл зүй*. Улаанбаатар.
- Цэвэл Я. 1966. *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.
- Ундрах Д. 2022. *Хятадын бүжгийн түүхийг зургаар өгүүлэхүй*. Улаанбаатар.
- Ундрах Д. 2022. *Ляо улсын судар*. Улаанбаатар.
- Сумьяабаатар М. 2005. *Гучин зургаатын тайлбар толь*. Улаанбаатар.
- Отгонуул Т., Мөнхчимэг Ц. 2021. *Зарлигаар тогтоосон манж нарын тайх тавиглах хууль бичиг*. Улаанбаатар.
- Хэрлэн Л. 2022. *Монгол хөгжмийн зэмсгийн өв соёл*. Улаанбаатар.
- Bilig, Ulayantuyay-a. 2013. *Manju-Mongyol-Kitad toli bičig, Ündüsün-u keblel-ün koriya*.
- Namjilm-a. 1994. *Qorin naimatu tayilburi toli. Öbür mongyol-un soyul-un keblel-ün qoriya*.
- Norjin Č. 1999. *Mongyol kelen-ü toli. Öbür mongyol-un keblel-ün qoriya*.
- 【元】脱脱. 1976. *《金史》中华书局 四库书 6*.